

## ГАРЧИГ

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>3</b>
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2 Төсөлд ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт .....	4
1.3 Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллагааны бүдүүвч схем .....	5
1.4 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө .....	7
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....</b>	<b>10</b>
2.1 Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлийг үнэлэх .....	13
2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим давтамж, нөлөөлөл үргэлжлэх хугацаа .....	19
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2015 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН .....</b>	<b>17</b>
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	17
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....	20
3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	20
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	20
3.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	20
3.6 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	20
3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	20
3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	27
3.9 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт .....	29
3.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт .....	26
<b>ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАГВАР .....</b>	<b>31</b>
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>32</b>

### ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	3
Хүснэгт 2. Уурхайд ашиглах тоног төхөөрөмж.....	4
Хүснэгт 3. Уурхайн ажлын горим.....	4
Хүснэгт 4. Шимт хөрсний овоолгын талбай эзлэхүүний тооцоо .....	5
Хүснэгт 5. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал.....	10
Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт.....	13
Хүснэгт 7. Гол сөрөг нөлөөлөл.....	16
Хүснэгт 8. Төсөл хэрэгжих үеийн гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим .....	16
Хүснэгт 9. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	17
Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	17
Хүснэгт 11. Усны чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ .....	18
Хүснэгт 12. Ургамал, амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	19
Хүснэгт 13. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	19
Хүснэгт 14. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	25
Хүснэгт 15. Байгаль орчны төлөвгөөний аудит хийлгэсэн хуваарь .....	28

### ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлийн топо зураг .....	3
Зураг 2 WSZ-1 маркийн цэвэрлэх байгууламжийн гаднах байдал .....	8
Зураг 3-4. Нөхөн сэргээлт хийгдэхээс өмнөх байдал.....	20
Зураг 5-6. Талбайд техникийн нөхөн сэргээлт хийж дууссаны дараах байдал.....	21
Зураг 7-10. Зам засварын ажил.....	23
Зураг 11. Энгийн хатуу хог хаягдал ангилан ялгах хэсэг .....	25
Зураг 12. Аюултай хог хаягдал хадгалах талбай.....	25
Зураг 13-19. Замын тэмдэг, тэмдэглэгээ .....	26

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр:** “Тэвш нуур” шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах, шохойн үйлдвэр байгуулах төсөл
- Төсөл хэрэгжүүлэгч:** “Э-Транс” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011075005, Регистрийн дугаар: 2546485, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-014799
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 2-р хороо, Улаанбаатар өртөө, 2 давхарт 1-2 тоот;  
Утас: 245908, 99079735

**Төслийн байршил:** Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотоос 140 км, Баянцагаан сумын төвөөс зүүн хойт зүгт 30.0 км-т, төмөр замын Мааньт өртөөнөөс баруун урд зүгт 40.0 км зайд оршино. Нийт 541.08 га талбайг хамарна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	Уртгаг	Өргөрөг
1	107° 19' 1.46”	46° 58' 1.68”
2	107° 16' 50.99”	46° 58' 1.68”
3	107° 16' 43”	46° 58' 6”
4	107° 16' 43”	46° 59' 1.68”
5	107° 19' 1.46”	46° 58' 1.68”



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршилын топо зураг

## 1.2 Төсөлд ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

### 1.2.1 Ил уурхайн тоног төхөөрөмж

Хүснэгт 2. Уурхайд ашиглах тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр, төрөл	Тоо
<b>Уурхайн уул тээврийн үндсэн тоног төхөөрөмж</b>		
1	Экскаватор CAT 330D	1
2	Экскаватор Hyundai 450LC	
3	Самосвал HOWO	2
4	Бульдозер SHANTUI ST23	1
5	Өрмийн машин Atlas Copco	1
6	Усны машин Hyundai	1
	Утгуурт ачигч SEM 656, SEM 650B	2
<b>Аж ахуй, үйлчилгээний автомашин, техник</b>		
7	Түлшний машин Dongfeng цестеринг	1
8	Ачааны машин Canter	1
9	Суудлын машин Pick up	2
-	Дүн	-

### 1.2 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2025 онд хүдрийн 1-р биетээс 721150 тн хүдэр, 31810 м<sup>3</sup> хөрс олборлохоор төлөвлөж ажилласан. Хөрс хуулалтын итгэлцүүр 0.3 м<sup>3</sup>/тн байна.

Тус онд 17540 м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийгдэж, 255000 тн хүдэр олборлосон.

### Уурхайн ажлын горим

Уурхай нь улс даяар тэмдэглэгддэг баяр ёслолын өдрүүдээс бусад өдөрт ажиллах бөгөөд цаг агаарын саатал, засвар үйлчилгээ зэргээс хамаарах зогсолтын өдрүүдийг ажлын өдөрт тооцно. Хоногт 1 ээлжээр ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажлын горим

Д/д	Хоног	Үзүүлэлтүүд
1	Жилийн нийт хоног	365
2	Баяр ёслолын өдөр	16
3	Цаг агаарын саатлын өдөр	15
4	Цэвэр ажлын хоног	300
5	Хоногт ажиллах ээлж	1
6	Ээлжинд ажиллах цаг	8

### **Уурхайн гадаад тээвэр**

Уурхайн тээвэрт хөрсийг гадаад овоолгод зөөх тээвэр, мөн хүдрийг хэрэглэгчид нийлүүлэх түүхий эдийн агуулахын талбайд хүргэх үйл ажиллагаа хамаарна. Хүдрийг 1.0 км зайд байрлах бутлан ангилах төхөөрөмжид, хөрсийг 0.5 км зайд орших хөрсний гадаад овоолгын талбайд тус тус тээвэрлэнэ.

### **Уурхайн овоолго**

Ордын хэмжээнд хуулах шимт хөрсний зузаан 0.05 м, Хөрсийг бульдозероор хуулан тухайн хэсэгт жижиг овоолго хийж экскаватороор авто тээвэрт ачин ажлын фронтын өрнөлтийн бус уурхайн хилийн гадна талд шимт хөрсний овоолго үүсгэнэ. Энэхүү овоолго нь 5 м-ээс ихгүй өндөртэй, тодорхой нягтаршуулалттай байна.

*Хүснэгт 4. Шимт хөрсний овоолгын талбай эзлэхүүний тооцоо*

№	Хурдас	Цулаар, м <sup>3</sup>	Кс	Сийрэгжсэн эзлэхүүн м <sup>3</sup>	Овоолгын өндөр м	Талбай	
						мян.м <sup>2</sup>	га
1	Хуулах хөрс	38618	1.2	46342	4	11.6	1.2

*Эхний 20 жилээр тооцов.*

Олборлолтын жилүүдэд шимт хөрсний овоолго байгуулахаар сонгосон талбайд 4.0 м өндөртэй, 130 м урттай, 90 м өргөнтэй талбайд овоолго үүснэ. Овоолгын эзлэх талбай нь 1.2 га.

### **Ил уурхайн барилга байгууламж**

- ✓ Нөөц тогтоогдсон 54.2 га талбай бүхий ил уурхай
- ✓ Шимт болон агуулагч чулуулгийн овоолго
- ✓ Захиргаа аж ахуйн контор
- ✓ Ажиллагсдын орон сууц
- ✓ Харуулын байр
- ✓ Хоолны газар
- ✓ Хүнс, түүхий эд, сэлбэг материалын агуулах
- ✓ Халуун ус, угаалгын газар, ариун цэврийн байгууламж
- ✓ Засварын газар
- ✓ Авто гараж
- ✓ Эрчим хүчний дэд станц
- ✓ Уурхайн өндөр хүчдэлийн шугам, трансформатор зэрэг орно.

**Агуулахын аж ахуй:** Ажиллагсдын хүнс, шатах тослох болон техник тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн шаардлагатай захиалгыг “Э-Транс” ХХК-ийн удирдлага хүлээн авч, ханган нийлүүлэх ажлыг хариуцдаг.

### **Хүнсний агуулах**

Хүнсний агуулах нь хүнсний түүхий эдийг муутгахгүй зориулалтын хөргөгч бүхий байгууламж байна. Энэхүү байгууламж нь дулааны улиралд хурдан муудах мах, жимс, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүнийг 7 хоног хадгалах хөргөгч, бусад хүнсний бүтээгдэхүүнийг 0.5 сар хадгалах боломжтой байхаар тоноглогдсон байдаг.

### **Шатах тослох материалын агуулах**

“МҮТТ” ХХК-ийн үйлдвэрлэсэн ST-25 маркийн 25000 л багтаамж бүхий түлш хадгалах түр сав байрлуулсан. Савны гадна урт 4700мм, диаметр нь 2700мм, жин 2600 кг байна. Савны тохирлын гэрчилгээ, паспортыг хавсаргав.



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: УБД0002179



СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Баталгаажуулалтын байгууллагын нэр

Аж ахуйн нэгж, байгууллага/нргэн:

Нэр: "МУТТ" ХХК

Утас/Факс: 96004380

И-мэйл: mutt.mn@gmail.com

Хаяг: Улаанбаатар хот, Сөнгинхайрхан дүүрэг, 11-р хороо, 3-121

Энэхүү гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт, бичгүүд:

1. Сорилтын дүнгийн дугаар, огноо: 7395/17 2017-06-23
2. Сорилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн нэр: Металл судлал, гагнуурын лаборатори
3. Удирдлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр:

СХЗГ-ын Бүтээгдэхүүний баталгаажуулалтын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 02/2021 тоот тэмдэглэл

Бүтээгдэхүүн үйлчилгээний тодорхойлолт:

1 Шатахууны ноолдох сав /ган/ 7309 MNS 5309:2003

Дээрхи бүтээгдэхүүн үйлчилгээ нь халбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү ГЭРЧИЛГЭЭ-г олгов.

В. ГАНЗОРИГ

Гарын үсэг/нэр

Б.Дэлгөнбаяр

Гарын үсэг/нэр



PC 03



2021-03-09

Олгосон огноо

2023-03-09

Дуусах огноо

### Сэлбэг хэрэгслийн агуулах

Сэлбэг хэрэгслийн агуулах нь уурхайн тоног төхөөрөмжийн түргэн элэгдэх эд анги, ажилчдын тосгоны сантехник, цахилгаан тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бусад туслах материалуудыг хадгалах түгээх зориулалттай байгууламж юм. Уг агуулахад гарч болзошгүй гэмтэл саатлыг цаг алдалгүй хурдан хугацаанд арилгахад чиглэгдсэн сэлбэг хэрэгслийг нөөцөлдөг. Зарим том оврын сэлбэг, эд ангийг гараажид тусгай талбайд хадгалдаг.

### Засварын газар, техникийн гараж

Уурхайн өдөр тутмын ажлыг гүйцэтгэж байгаа техник тоног төхөөрөмж, механизмыг засварлах, байрлуулах зориулалттай битүү гарааж байдаг. Энэ нь уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд, суудлын тэрэг зэрэг машин техникүүд байрших боломжтой байдаг. Засварын газарт төлөвлөгөөт болон урсгал засварыг зохион байгуулж, сул зогсолт гаргахгүй байх нөхцлийг ханган ажилладаг.

Уурхайн засварын хэсэг нь дотоод шаталттай хөдөлгүүртэй тоног төхөөрөмжийн урсгал ба үндсэн засвар, дугуй засвар зэрэг техник үйлчилгээний ажлуудыг хийдэг.

Мөн цахилгаан хөдөлгүүр, генератор, цахилгаан аппарат, хэмжих багаж хэрэгсэл, тоноглолын техникийн үйлчилгээ, урсгал засварыг гүйцэтгэдэг.

Засварын газарт гагнуурын аппарат, огтлогч, таслагч, өрөм, токерийн машин, дугуй засвар зэрэг засварын үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан тоног төхөөрөмжүүд байдаг.

### Дулаан хангамж

Уурхайн контор, ажилчдын орон сууц, цайны газрын халаалтыг БНХАУ-д үйлдвэрлэгдсэн 2000 м<sup>2</sup> талбайг халаах хүчин чадал бүхий нам даралтын босоо зуухыг ашигладаг.

### Усан хангамж

Төсөлд ашиглагдах усан хангамжийг хангахаар төслийн талбайд 3.1 л/сек ундаргатай гүний худаг гаргаж ашиглалтанд бэлдсэн. Худгийн паспортыг хавсаргав.

### Ус таталт шүүрүүлэлт

Тус ордод хайгуулын явцад гидрогеологийн судалгаа хийж ус агуулагдах байдал, газрын доорх усны түвшинг тодорхойлох зорилгоор ажиглалт, судалгаа хийгдсэн.

Талбайн хэмжээнд усан сүлжээ муу хөгжсөн, усгүй хуурай гадаргуутай. Гадаргуугийн ус ховор, булаг шанд нь тухайн жилийн хур тунадаснаас хамаарч ундарга нь хэлбэлзэж, гантай жил ширгэнэ. Хүдэр агуулсан хурдас нь ордын бага талбайд элс элсэнцэр, бор шороон хөрснөөс бүрдсэн сэвсгэр хурдсаар маш бага хэмжээгээр (5см) хучигджээ. Хучиж буй хурдасны чулуулгийн бүрэлдэхүүнээс үзэхэд уг хурдас нь хур тунадасны ус нэвчин шингэхэд тохиромжтой болно. Хайгуул хийгдсэн талбайд газрын доорх ус агуулсан давхарга тогтоогдоогүй тул ус шүүрүүлэх шаардлагагүй юм.

### Усны хэрэглээ:

Зам талбайн усалгаа: Хөрсийг уурхайн нөөц тооцоолсон хилийн гадна, уурхайгаас 1.2 км зайд байрлах гадаад овоолгод тээвэрлэнэ. Замын өргөн нь 4 м:

$$1200\text{м} * 4\text{м} = 4800\text{м}^2$$

Хуурайшилттай, салхины хурд 8 м/с-ээс их (14 м/с хүртэл) үед хийх усалгааны нормыг баримталж  $4800\text{м}^2 \times 2\text{л} \times 45 \text{хоног} = 432\text{м}^3$ , өдөрт  $9.6 \text{м}^3$  усаар зам талбайг усалсан.

**Унд ахуйн усан хангамж:** Усыг ахуйн хэрэглээнд хэрэглэх ба уурхайн дэргэдэх өөрийн худгаас чайнад татаж дүүргэн, түгээх журмаар ашиглана. Нийт 32 хүн ажилласан. Хоногт 1 хүнд дунджаар 150 л ус /БОНХАЖСайдын А/301-р тушаалын 12-р хавсралтын дагуу/ хэрэглэхээр тооцвол усны хэрэгцээ нь 4800 л/хоног.

$$\text{Жилд } 4800 * 300 = 144000 \text{ л/жил} = 1440 \text{ м}^3/\text{жил}$$

**Нийт ашигласан усны хэмжээ  $432\text{м}^3 + 1440\text{м}^3 = 1872 \text{ м}^3/\text{жил}$**

Усны төлбөр тооцохдоо байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газрын газар доорхи усны үнэлгээг үндэслэл болгосон. Энэ үнэ нь 3700 төгрөг унд ахуйн усны төлбөрийг 0.6 коэффициентээр үржүүлж унд ахуйн хэрэгцээнд зарцуулсан усны төлбөрийг 0%-иар, зам талбайн усалгааг 0.5 коэффициентээр үржүүлж зам талбай усалгаанд зарцуулсан усны төлбөрийг 20%-иар тус тус тооцож ус ашигласны төлбөрийг тухай бүрт төлж байсан.

### ***Түүхий эд, туслах материал, завсрын болон эцсийн бүтээгдэхүүн, хог хаягдал***

#### ***Түүхий эд, туслах материал***

Ил уурхайн техник, тоног төхөөрөмжүүдийг тогтмол ажиллуулахад шаардлагатай материал нь дизель түлш, тослох материалуудаар тодорхойлогдоно.

Уурхайд нэг жилд шаардагдах материал

- Дизель түлш – 333700 л

#### ***Хог хаягдал***

**Ахуйн хатуу хог хаягдал:** Нийт 32 хүн ажилласан ба жилд 3500 кг хуурай хог гарсан. Хуурай хог хаягдлыг тусгай талбайд, тагтай битүүмжлэл сайтай хогийн саванд хадгалдаг. Сар бүр орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт ачин аваачдаг.

**Ахуйн шингэн хог хаягдал:** Хоногт дунджаар 1008 л хаягдал ус гарсан.

Манай компани 2017 онд БНХАУ-ын Shandong Zhucheng хотын “Shandong Better environmental Protection Technology” ХХК-ний үйлдвэрлэдэг WSZ-1 маркийн дунд оврын цэвэрлэх байгууламжийг суурилуулан болно.

Уг байгууламж нь автомат удирдлагатай, бохирын хэмжээнээс шалтгаалан нэг удаагийн цэвэрлэх ажиллагаа нь 24-72 цагийн хооронд явагддаг. Тогны хэрэглээ маш бага. Цэвэрлэх байгууламжаас гарсан ус нь 98-99% хүртэл цэвэрлэгдэх ба уг усаар ногоо услах, мал услах, барилгын ажил болон бусад аж ахуйн ажилд хэрэглэх шаардлага хангасан байдаг.

#### ***Хийн хаягдал***

Манай уурхайн хувьд хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашин, зуухнаас ялгарах утаа зэрэг байна.

Агаарын бохирдлын шинжилгээг жил бүр хийлгэдэг ба тус шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ хэвийн хэмжээнд гардаг. Хэмжээнээс хэтэрсэн тохиолдол гарч байгаагүй.



*Зураг 2. WSZ-1 маркийн цэвэрлэх байгууламжийн гаднах байдал*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### 2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх

#### 2.1.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших “Тэвш нуур” шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах, шохойн үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн барилгын материал үйлдвэрлэл явуулснаар байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох гол нөлөөллийн үнэлгээг нарийвчлан тогтоож, түүнийг бууруулах, байгалийн унаган төрхийг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг боловсруулахын тулд Монгол орны нөхцөлд эрдэс баялаг, ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үед гарч болох сөрөг нөлөөлөл, НҮБ-ийн Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 1992 онд одоогоор манайд хэрэглэгдэж байгаа магадлан жагсаах арга, матрицын арга зэргийг ашиглав.

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг билээ.

Энэ арга нь олборлолт хийх болон шохой үйлдвэрлэх үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв тухайн нөлөөлөл байвал “х”- ээр тэмдэглэдэг.

Төв аймаг Баянцагаан сумын нутагт орших “Тэвш нуур” шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах, шохойн үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэж хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 5. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал*

№	Нөлөөллийн төрөл	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт</b>											
1	Гадаргын усны урсацын өөрчлөлт										
2	Гадаргын усны чанарын өөрчлөлт										
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x			x
4	Хөрсний элэгдэл эвдрэл	x				x		x			x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x			x
6	Зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x					x		
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x			x

**“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

9	Бэлчээр тэжээлийн байдал	x				x		x		x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
11	Эрчим хүчний нөөц										
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>											
12	Ундны усны чанар хэмжээ		x							x	
13	Урсгал усны хэрэгцээ										
14	Агаарын бохирдол	x			X					X	
15	Хөрсний бохирдол	x				x		x		x	
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x					x			x
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	x			X						x
<b>4. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>											
18	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x	x		
19	Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд нөлөөлөх							x		x	x
20	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	x				x		x		x	
21	Хүн амын тоо өөрчлөгдөх										
<b>5. Байгалийн цогцолбор газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>											
22	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
23	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
24	Тусгай хамгаалалттай ба цогцолбор газарт нөлөөлөх										
25	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
26	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
<b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>											
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x	x		
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			X	x		X		x	
30	Ажлын байр нэмэгдэх	x		x	X	x		X		x	
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		x		X	x					
<b>7. Бусад нөлөөлөл</b>											
32	Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	

**“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

33	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах	x				x		x	x	x	
34	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			X		x			x	
<b>Дүн</b>		<b>22</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>18</b>	<b>2</b>	<b>19</b>	<b>6</b>	<b>14</b>	<b>7</b>

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

**Эерэг нөлөөлөл**

- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх

**Сөрөг нөлөөлөл**

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл, эвдрэл
- ✓ Геологийн тогтоцын өөрчлөлт
- ✓ Зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлт
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Дуу чимээ шуугианы нөлөөлөл
- ✓ Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх
- ✓ Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд Тэвш нуурын шохойн чулууны ордын үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "x"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “x” гэж бөглөв.

**“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт*

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
<b>✚ Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	x			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	x			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох		x		
<b>✚ Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал</b>				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				X
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			x	
Шохойн үйлдвэр байгуулах, олборлолт хийх үед болон үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				X
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх			x	
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		x		
<b>✚ Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал</b>				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		x		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				X
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x	
<b>✚ Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал</b>				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			x	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
<b>✚ Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)</b>				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				X

*Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл*

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

*Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал*

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар бага зэргийн үр дагавартай байна.

### 2.1.2 Голлох нөлөөллийн үнэлгээ

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөллийн үнэлгээнд байна. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

#### *Агаарын чанарт нөлөөлөх байдал*

Төслийн ойр орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэн тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, шохой бутлах, нунтаглах ажлын үед тоос босохоос гадна шохой шатаах зуух, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ.

- ✓ Хөрс хуулах
- ✓ Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно
- ✓ Шохойн чулуу олборлох үед үүсэх тоос
- ✓ Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос
- ✓ Хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий
- ✓ Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос
- ✓ Барилгын ажлын үед гарах тоос
- ✓ Шохойн чулуу шатааснаас үүсэх хийнүүд
- ✓ Шохойн чулуу боловсруулснаас үүсэх тоос
- ✓ Тэсэлгээ хийх үед босох тоос болон агаарт хорт бодисууд ялгарах

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

Агаар орчныг бохирдуулагч бусад эх үүсвэр нь тухайн ажлыг гүйцэтгэх үед үүсэх бөгөөд агаар бохирдуулах цаг хугацаа болон агаарын бохирдлын хэмжээ, хамрах хүрээгээрээ харилцан адилгүй байдаг.

#### *Газрын хэвлий, гадаргад нөлөөлөх байдал*

Төслийн талбай нь Төв аймгийн Баянцагаан сумын нутагт MV-014799 тоот тусгай зөвшөөрөл бүхий 541.08 га талбайг эзлэн оршино. Үүнээс 57.5 га талбайд уурхай, шохойн үйлдвэр, ахуйн үйлчилгээний объектууд, тосгон зэргийг байршуулахаар төлөвлөсөн байна. Энэ талбай нь ямар нэг хэмжээгээр эвдэрч талхлагдана. Үүнээс газрын хэвлий, гадарга хамгийн их өртөх талбай нь ил уурхайн талбай юм.

#### *Усан орчинд нөлөөлөх байдал*

Тухайн районд усан хангамжийн эх үүсвэр нь газрын доорх ус юм.

Газрын доорх ус нь цэнгэг, рН: 7.6, ерөнхий хатуулаг нь 4.5 мг-экв/л байгаа нь унд ахуйн хэрэгцээний усны стандарт MNS 900:2005-ын шаардлагыг хангаж байна.

Төсөл хэрэгжих талбайн орчимд гадаргын ус байхгүй. Тиймээс төслийн хүрээнд ашиглагдах усны хэрэгцээг төслийн талбайд байрлах гүний худгаас хангахаар төлөвлөсөн бөгөөд усны шинжилгээг хийлгэж, худгийн паспортыг гаргуулсан.

Төслийн хүрээнд ашиглах усыг гүнээс татах учир гүний усны нөөцөд тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

*Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал*

Баянцагаан сум орчмын хөрс нь “нунтаг карбонатлаг бор хүрэн” хөрсний ангилалд багтана. Энэ хэв шинжийн хөрс Дорнод Монголын тал хээрийг бүхэлд нь хамарсан байдаг.

Хөрсний давхаргад гипс үгүй, хялбар уусах давс бага хэмжээтэй агуулагдах бөгөөд механик бүрэлдэхүүнээр шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс голлож, ямар нэг хэмжээгээр сайр чулуутай буюу элсжсэн байдалтай болсон. Морфологийн онцлог нь ялзмагийн давхарга сааралдуу буюу гэгээтэй тод хүрэн өнгөтэй, хуурай тоосорхог бөөмөнцөр бүтэцтэй, элсэнцэр бүтэц нь тодорхой бүтэцгүй, хөрсний бүх давхарга сайр чулуугаар элбэг, эсвэл элсэрхэг, ялмагт үе нь харьцангуй нимгэн. Хөрсний механик бүрэлдэхүүнд хөнгөн шавранцар, элсэнцэр, элс зонхилох, уур амьсгал хуурай учир хөрсний үржил шимт хэсэг салхинд идэгдэж хийсэх, элэгдэх аюул ихтэй.

Уурхай, шохойн үйлдвэр орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

*Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал*

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн мужийн Төв Азийн дэд их мужийн Монголын хээрийн мужийн Дундад халхын дэд мужид багтана.

Энд хааяа уулс, цав толгод, тал газрын Монгол хэв шинжийн жижиг бутлаг үетэн-хялганат бүлгэмдэл зонхилох бөгөөд чулуусаг алаг өвс-хялганат бүлгэмдэлтэй хосолсон чулуусаг алаг өвс- хялганат бүлгэмдэл дагалдагчийн үүрэг гүйцэтгэнэ.

Шохойн үйлдвэр, ажилчдын тосгон барих үеийн хөрс хуулалтаар ургамлан нөмрөг устах, тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах, ургамлын ургах чадвар муудах, ургамлан нөмрөг багасч халцгай газрын талбай нэмэгдсэнээр хөрс салхиар хийсэх, усанд урсах зэргээр газрын эвдрэл нэмэгдэх, хөл газрын ургамлууд бүлгэмдэлд түрснээр бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээ улам багасч тухайн нутагт бэлчээрийн даац хэтрэх зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй байна.

*Амьтны аймагт нөлөөлөх байдал*

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавьж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Хөрсөнд амьдардаг азот, бусад органик шим бодисыг нийлэгжүүлэхэд оролцдог микроорганизмын бүтэц, бүрэлдэхүүнд тодорхой хэмжээний өөрчлөлт орно. Эдгээр микроорганизмууд нь газрын дээр болон хөрсөнд хуримтлагдсан задарч амжаагүй ургамал, амьтны үлдэгдлийг задалж ялзруулан хөрсөнд шим тэжээлт бодисыг буй болгоход ихээхэн үүрэгтэй.

**“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хөрсний микроорганизмын бүрэлдэхүүн өөрчлөгдөж үүний улмаас тэдгээрийн бодисын солилцоонд өөрчлөлт гарснаар тухайн экосистемийн бүтэц, үйл ажиллагаа ямар нэгэн хэмжээгээр сөрөг байдлаар өөрчлөгдөж болзошгүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

**2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим давтамж, нөлөөлөл үргэлжлэх хугацаа**

Төсөл хэрэгжих үеийн болон төслийн өмнөх үеийн үнэлгээний зөрүү нь байгалийн байдал, байгалийн нөөц, түүний дотор геологийн тогтоц, хөрс, газрын доорхи усны нөөц, агаар, хөрсний үржил шим зэрэгт хамгийн илүү сөрөг нөлөөтэй байх нь харагдаж байна. Иймд эдгээр голлох сөрөг нөлөөллийн эрч хүчийг бууруулах, цаашид арилгах арга хэмжээг тодорхой үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсөл хэрэгжсэнээр улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх болно.

*Хүснэгт 7. Гол сөрөг нөлөөлөл*

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, 0хөрс	57.5 га талбайн хөрс, ургамал нь бүр мөсөн дарагдаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Тэсэлгээ хийх, хөрс хуулах, олборлолт хийх, ачих, тэвэрлэх, шохойн чулууг бутлах, шигших, овоолго үүсгэх, шохойн чулууг шатаах зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед үлэмж их хэмжээний тоос бусад төрлийн химийн бодис агаарт дэгдэж хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.
3	Ургамал	Нийт 57.5 га талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Ил уурхайн олборлолт явуулах талбайн ургамлан нөмрөг бүрэн устаж хоосон орон зай бий болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

*Хүснэгт 8. Төсөл хэрэгжих үеийн гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим*

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	38.6 мян.м <sup>3</sup> шимт хөрс хуулна.	Хүчтэй	Төсөл хэрэгжих хугацаа эхний 20 жилд
2	Шохойн чулуу олборлолт	Геологийн тогтоц, гүний ус, агаар	150 сая.тн шохой олборлох	Хүчтэй	20 жил
3	Тэвэр	Хөрс, агаар	Агаарын орчин тоосоор бохирдоно	Дунд зэрэг	20 жил
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Шимт хөрс болон хоосон чулуулгийн овоолго 2.5 га талбайг эзэлнэ.	Хүчтэй	20 жил

Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмээс харахад дээрх нөлөөллийн эрчмийг бага байлгах, бууруулах, арилгах талаар байгаль орчныг нөхөн сэргээх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээг тогтмол хийлгэж, мониторингийн хөтөлбөрийг мөрдөж ажиллаж байна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

*3.1.1 Төслийн агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

*Хүснэгт 9. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Үр дүн	Баримтлан ажилласан стандарт аргачлал
<ul style="list-style-type: none"> <li>Орчинд тоосжилт ихсэхээс хамгаалж, зам усалгааны цистерн ажиллуулах, төлөвлөгөөний дагуу зам услах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тохируулгыг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандарт шаардлагын хэмжээнд байлгахад анхаарч машин техникт тогтмол засвар хийж байсан.</li> <li>Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор сургалт сурталчилгаа явуулж, хамгаалах хэрэгслээр хангасан.</li> <li>Авто машины зориулалтын зогсоолыг засч сайжруулсан.</li> <li>Уурхайн замыг зөвхөн нэг маршрутаар явуулдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурийн газрын агаарын чанарыг хянах журам: MNS 17.2.3.16 - 1988</li> <li>Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384 - 1982</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Ахуйн хаягдалыг тусгайлан бэлтгэсэн битүү хаалттай саванд ангилан хийж, хаягдлын нэгдсэн цэгээс хуурай хөнгөн хаягдал хийсэхгүй байх, нарийн ширхэгтэй тоос шороо үүсгэхгүй байх нөхцлийг хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдалыг тусгайлан бэлтгэсэн битүү хаалттай саванд ангилан ялгаж, тогтмол хугацаанд графикайн дагуу хог хаягдлыг тээвэрлэснээр муухай үнэр гарах, ялаа, шавьж үржих, хог хаягдал салхиар хийсч ойр орчмын газрыг бохирдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлж ажилласан.</li> </ul>	

*3.1.2 Төслийн хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах*

*Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Үр дүн	Баримтлан ажилласан стандарт аргачлал
<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн эдэлбэр газрын хил хязгаарын тэмдэгжүүлэлт хийж, олон салаа зам гаргахгүй байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож, замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавьж тэмдэгжүүлсэн.</li> </ul>	Газрын төлөв байдал, чанарын хяналт баталгаа явуулах журам, мөн УСТ 12-156-91
<ul style="list-style-type: none"> <li>Хатуу хог хаягдал, ахуйн химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Баянцагаан сумын байгаль орчны байцаагчтай хог хаягдлын гэрээ байгуулан тогтмол хугацаанд хог хаягдлыг тээвэрлэсэн.</li> </ul>	

<p>✚ Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших</p>	<p>✚ Уурхайд ажиллах машин болон бусад техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засвар хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд гүйцэтгэдэг.</p>	<p>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008</p>
---	--	--

### 3.1.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Хүснэгт 11. Усны чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Үр дүн	Баримтлан ажилласан стандарт аргачлал
<p>✚ Усны менежментийн зохистой үйл ажиллагааг явуулж, хэрэгжүүлэх, болзошгүй эрдслийг бууруулах талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх, хяналтыг сайжруулах</p>	<p>✚ Усны менежментийн зохистой үйл ажиллагааг явуулж, хэрэгжүүлэх, болзошгүй эрдслийг бууруулах талаар ажилчдад заавар зөвлөгөө өгч сургалт явуулсан.</p>	<p><b>MNS (ISO)5667-14:2000</b> Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж <b>MNS 13.060.50</b> Усны чанарын стандарт</p>
<p>✚ Хөрсний усанд бохирдол шингэхээс сэргийлэх, техник тоног төхөөрөмжийг зөв зохистой ашиглах, хог хаягдлыг зайлуулах менежментийг сайжруулах</p>	<p>✚ Хөрсний усанд бохирдол шингэхээс сэргийлж техник тоног төхөөрөмжид тогтмол техникийн үзлэг шалгалт хийж, зориулалтын засварын талбайд засвар үйлчилгээг хийн зөв зохистой ашиглах тал дээр хяналт тавин ажилласан.</p>	
<p>✚ Ус ашиглалтын төлбөрийг зохих журмын дагуу тооцож, орон нутгийн байгууллагад тогтоосон хугацаанд нь төлж байх</p>	<p>✚ Ус ашиглалтын гэрээ байгуулж, төлбөрийг зохих журмын дагуу орон нутгийн байгууллагад төлж байсан.</p>	
<p>✚ Ажилчид болон орон нутгийн иргэд ахуйн усанд ашиглахаар төлөвлөж буй болон ашиглаж байгаа худаг, ил задгай уснаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг тодорхойлох</p>	<p>✚ Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж буй худгийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулан ундны усны стандартад нийцэж буйг тодорхойлуулсан.</p>	
<p>✚ Ахуйн бохир усыг ус, хөрс бохирдуулахгүй цооногт хуримтлуулан ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх, дахин боловсруулж үйлдвэрт ашиглах технологийг хэрэглэх</p>	<p>✚ Ахуйн бохир усыг ус, хөрс бохирдуулахгүй байлгах аргаар тооцоолон бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэдэг.</p>	

3.1.4 Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Хүснэгт 12. Ургамал, амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Үр дүн	Баримтлан ажилласан стандарт аргачлал
✚ Эвдрэлд, доройлтолд ороогүй газруудад машин техникүүдийг явуулахгүй байх	✚ Эвдрэлд, доройлтолд ороогүй газруудад машин техникүүдийг явуулахгүй байхаар замын эхэнд болон төгсгөлд тэмдэг тэмдэглэгээг байршуулж хяналт тавин ажиллаж байна.	MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
✚ Хаягдал чулуулгийн овоолго, хаягдал хадгалах байгууламжийн дээр ургамлан нөмрөгийг нөхөн сэргээх	✚ Шимт хөрсний овоолго болон хаягдал чулуулгийн овоолго дээр ургамлан нөмрөгийг нөхөн сэргээсэн.	
✚ Уурхайн тосгоны ойр орчимд ногоон байгууламж бий болгох.	✚ Уурхайн тосгон орчимд ногоон байгууламжийг бий болгож мод тарьсан боловч малд идүүлсэн. 2025 онд хашаажуулж дахин мод тарина.	
✚ Ан амьтныг судлах, хамгаалах хяналт тавих талаар нутгийн удирдлага, ард иргэдтэй хамтран ажиллах.	✚ Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран ан амьтныг хамгаалах тал дээр хяналт тавин ажилласан.	Амьтны тухай хууль

3.1.5 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах

Хүснэгт 13. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Үр дүн	Баримтлан ажилласан стандарт аргачлал
✚ Ашиглалтын үйл ажиллагаа, тоног төхөөрөмж тээвэрлэлт явагдахаас өмнө тээвэрлэлт хийх замын маршрут, зураг төсөл гарган, баталж, тогтсон маршрутын дагуу явах шаардлагатай ба авто замын засвар үйлчилгээгээр тогтмолжуулах	<ul style="list-style-type: none"> <li>✚ Тээвэрлэлтийн замыг сайжруулах зорилгоор “Монголчех Металл” ХХК-тай өмнөх жилүүдэд хамтран хийсэн сайжруулсан шороон замын 24 км замыг 2025 онд дахин сайжруулж хайрган хучилттай болгон заслаа. Зам засварын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн анд” ХХК-тай гэрээлэн гүйцэтгүүлсэн.</li> <li>✚ Газар ашигласны төлбөрийг тухай бүрт нь улсын төсөвт төвлөрүүлсэн.</li> </ul>	Газрын хэвлийн тухай хууль
✚ Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр олон салаа зам гаргах, замгүй газраар тээврийн хэрэгсэл зорчихыг хориглох	✚ Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр олон салаа зам гаргахгүй байх, замгүй газраар тээврийн хэрэгсэл зорчихгүй байх тал дээр хяналт тавин, тэмдэгжүүлэн бетон суурьлуулж, олон зам гаргахаас сэргийлж ажиллаж байна.	

**“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт*

Ордын уул техникийн нөхцөл нь нөхөн сэргээлтийн ажлыг тухай бүрт хийх боломжгүй учир нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан.

*3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

Дүйцүүлэн хамгаалах ажлаар тус онд Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших булаг, шандын эхийг хашаажуулан хамгаалсан болно.

*3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний  
төлөвлөгөөний биелэлт*

Уурхайг 70 жил ашиглах бөгөөд үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

*3.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний  
төлөвлөгөөний биелэлт*

Ашиглалтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

*3.6 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Өрөмдлөг тэсэлгээг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлдэг.

*3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Төв аймгийн Баянцагаан сумын байгаль орчны байцаагчтай 2025 оны 01 сарын 25-ний өдрөөс 2025 оны 12 сарын 25-ны өдөр хүртэл хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу хог хаягдлыг цаг хугацаанд нь тогтмол зайлуулсан.

*3.8 Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

*Хүснэгт 14. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн
Байгаль орчны асуудлыг хариуцан зохион байгуулах үүргийг компанийн удирдлагын хүрээний ажилтандаа хариуцуулан ажиллуулах	✓ Уурхайн дарга хариуцан ажиллаж байна.
Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалт зохион байгуулах	✓ Ажилчдад байгаль орчныг хамгаалах, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврын талаар ажилд гарахаас өмнө 10 минут сургалт явуулдаг.
Байгаль орчныг хамгаалах асуудлаарх жилийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх	✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгдөг.
Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг БОАЖЯ-аар хянуулан баталгаажуулах	✓ 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг удирдан зохион байгуулсан. ✓ Төрийн сангийн дансанд 2025 оны Нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болох 4,500,000.00 төгрөгийг байршуулсан. /Баримтыг хавсаргасан /
Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлыг тусад нь төлөвлөж байх	✓ Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлыг тусад нь төлөвлөж өгсөн.

“Тэвш нуур” шохойн чулууны ордын 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---

Тээвэрлэлтийн замыг сайжруулах зорилгоор “Монголчех Металл” ХХК-тай өмнөх жилүүдэд хамтран хийсэн сайжруулсан шороон замын 24 км замыг 2025 онд дахин сайжруулж хайрган хучилттай болгон зассан. Зам засварын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн анд” ХХК-тай гэрээлэн гүйцэтгүүлсэн. (Гэрээг хавсаргав)



*Зураг 7. Зам засварын ажил*





*Зураг 9. Зам засварын ажил*



Энгийн болон аюултай хог хаягдлын ангилан ялгалтыг хийж, хог хаягдлыг зөв зохистой устгах зайлуулах тал дээр анхаарч ажиллаж байна.



*Зураг 11 . Энгийн хатуу хог хаягдал ангилан ялгах хэсэг*



*Зураг 12. Аюултай хог хаягдал хадгалах талбай*

Олон салаа зам үүсгэхгүйн тулд замын тэмдэг, тэмдэглэгээг хийж өгдөг.



Зураг 13. Замын тэмдэг, тэмдэглэгээ





Зураг 17. Замын тэмдэг, тэмдэглэгээ



*3.9 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт*

*Хүснэгт 15. Байгаль орчны төлөвлөгөөний аудит хийлгэсэн хуваарь*

<b>БОМТ хэрэгжилтийг тайлагнах хэлэлцүүлэх байгууллага</b>	<b>Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр</b>	<b>Мэдээллийн агуулга</b>	<b>Хугацааны тов</b>	<b>Зохион байгуулсан газар</b>
Төсөл хэрэгжиж буй талбай орчмын иргэд, холбогдох хүмүүс	Хурлаар	Уурхайн үйл ажиллагаа болон төсөл хэрэгжиж буй талбайн өнөөгийн байдлыг танилцуулав.	8-р сар	“Баян-айраг” багийн төв
“Э-Транс”ХХК “Баянцемент”ХХК	Тэмцээн	Сумын байгууллага, алба хаагчид болон олон нийтийг хамарсан сагсан бөмбөг болон волейболын тэмцээн зохион байгуулна.	11-р сар	Баянцагаан сум

*3.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт*

**Уурхайд ашиглагдаж буй ундны усны шинжилгээ:**

Уурхайн унд ахуйн ус хангамжийг уурхайн тосгоноос зүүн тийш 50 м-т байрлах гүний худгаас хангадаг.

Уг шинжилгээний дүгнэлтээр уурхайн усан хангамжид хэрэглэдэг ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь ундны усны стандарт MNS900:2005-ын шаардлагаг хангаж байна. (Лабораторийн дүнг хавсаргав)

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАГВАР**

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Биелэлтийн хувь	Тайлбар, үндэслэл
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100	Сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн. <ul style="list-style-type: none"> <li>✓ Тоосжилт үүсэхээс хамгаалж авто замын усалгааг хийсэн.</li> <li>✓ Тээвэрлэлтийн замыг сайжруулах зорилгоор “Монголчех Металл” ХХК-тай өмнөх жилүүдэд хамтран хийсэн сайжруулсан шороон замын 24 км замыг 2025 онд дахин сайжруулж хайрган хучилттай болгон заслаа. Зам засварын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн анд” ХХК-тай гэрээлэн гүйцэтгүүлсэн.</li> <li>✓ Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр олон салаа зам гаргахгүй байх, замгүй газраар тээврийн хэрэгсэл зорчихгүй байх тал дээр хяналт тавин, тэмдэгжүүлэн бетон суурьлуулж, олон зам гаргахаас сэргийлж ажиллаж байна.</li> <li>✓ Уурхайд ажиллагсдыг тоосжилтоос хамгаалах хэрэгсэлээр хангасан.</li> <li>✓ Хог хаягдал болон бохирын цэгийг ариутган, халдваргүйжүүлсэн.</li> <li>✓ Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах зорилгоор Төв аймгийн Баянцагаан сумтай гэрээ байгуулан ажилладаг.</li> </ul>
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	100	Ордын уул техникийн нөхцөл нь нөхөн сэргээлт хийх боломжгүй учир нөхөн сэргээлтийн зардлыг тусгай дансанд байршуулсан.
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах Ээвж хэмээх газрын орхигдсон 2.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөв/биелэлт	-	Ашиглалтын явцад нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор аваагүй болно.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-	Ашиглалтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.
6	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	-	Ашиглалтын явцад химийн бодис ашиглаагүй болно.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	100	Баянцагаан сумтай 2024 оны 01 сарын 25-наас 2024 оны 12 сарын 25 хүртэл хог хаягдлын гэрээ байгуулсан.
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн тайлан	100	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОНХЯ-аар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг удирдан зохион байгуулсан.
9	Олон нийгэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	-	8-р сард уурхайн үйл ажиллагаа болон төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг Баян-айраг 2-р багийн иргэдэд танилцуулсан.
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрын биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэл	100	Ус, хөрс, агаар, саарал усны шинжилгээг БОХЗүйн лабораториор хийлгэсэн.
	Дүн /арифметик дундаж/	100	

## Дүгнэлт

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Уурхайн ажиллагсдыг тоосжилтоос хамгаалж хамгаалах хэрэгсэлээр хангасан.

Хог хаягдал болон бохирын цэгийг ариутган халдваргүйжүүлсэн.

Ус, хөрс, агаар, саарал ус, дуу чимээний шинжилгээг БОХЗүйн лабораториор хийлгэсэн.

Тээвэрлэлтийн замыг сайжруулах зорилгоор “Монголчех Металл” ХХК-тай өмнөх жилүүдэд хамтран хийсэн сайжруулсан шороон замын 24 км замыг 2025 онд дахин сайжруулж хайрган хучилттай болгон заслаа. Тус ажилд нийт 127.5393 сая.төгрөг зарцуулсан.